



ҮАГ

"Их эзэн Чингис хаан хөшөө, Төрийн ёслол, хүндэтгэлийн өргөө" цогцолборыг барьж байгуулахад улсын төсвөөс 2005 онд олгосон хөрөнгийн гүйцэтгэл



Барилга угсралтын ажил хугацаандаа хийгдээгүй байна

УИХ-ын Төсвийн Байнгын хорооны хүсэлтээр хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

Улаанбаатар 2006 оны 2 дугаар сар

Агуулга

Тайланг бэлтгэсэн: ҮАГ-ын нэгдүгээр хэлтэс <i>Тэргүүлэх аудитор</i> Д.Ганбилэг <i>Ахлах аудитор</i> С.Сэрчхорол <i>Аудитор</i> С.Андруш <i>Шинжээч</i> Ц.Эрдэнэчулуун 2006 оны 2 дугаар сар Уг тайланг ҮАГ-ын вэб сайт-аас үзнэ үү: www.mnao.pmis.gov.mn <i>Аудитын тайлан, дүгнэлттэй</i> <i>холбоотой асуудлаар нэмж</i> <i>тодруулах, асууж лавлах зүйл</i> <i>байвал 261885 дугаарын утас,</i> <i>323266 дугаарын</i> <i>факсаар харилцана уу.</i> ХАЯГ: <i>Үндэсний аудитын газар</i> <i>Засгийн газрын 4 дүгээр байр,</i> <i>Бага тойруу-6, Улаанбаатар-46</i> <i>Монгол Улс</i>	Товчилсон үгсийн жагсаалт	3
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4
	Бүлэг 1	
	<ul style="list-style-type: none">"Их эзэн Чингис хаан хөшөө, Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө" цогцолборыг барьж байгуулах талаар шийдвэр гарч, зарим нэг арга хэмжээ авчээ	5
	<ul style="list-style-type: none">Улсын төсвийн санхүүжилтийг хугацаанд нь олгоогүй байна	6
	<ul style="list-style-type: none">Захиалагч, хэрэгжүүлэгч байгууллагууд гүйцэтгэгчдэд санхүүжилтийг бүрэн олгоогүйгээс хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна	8
	<ul style="list-style-type: none">Захиалагч гэрээнд тусгагдаагүй байгууллагад хэрэгжүүлэгчээр дамжуулалгүйгээр санхүүжилт олгожээ	9
	<ul style="list-style-type: none">Зураг төсөл, уран баримал, барилга угсралтын ажлын гүйцэтгэлд захиалагчийн зүгээс тавих хяналт хангалтгүй байна	9
	<ul style="list-style-type: none">Зураг төсөл, уран баримал, барилга угсралтын ажлын санхүүжилтээс зориулалт бусаар	9

Агуулга

зарцуулжээ

Бүлэг 2

- Зураг, төсөл эцэслэн гараагүйгээс барилга угсралтын ажил удааширч байна. 10
 - Цогцолборын эхний ээлжинд төлөвлөсөн ажил хугацаандаа хийгджээ. 11
 - Зураг төсөл хугацаандаа хийгдээгүй, гүйцэтгэгч солигдсоноос барилга угсралтын ажил удааширч байна. 11
 - Барилга угсралтын ажилд тавих техникийн хяналтыг онцлон анхаарч бүрэн гүйцэд хийх шаардлагатай байна. 12
 - Холбогдох байгууллагын санал, тайлбар 15
-

Товчилсон үг

УИХ	Улсын Их Хурал
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ТЗҮААЭГ	Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газар
НХОГ	Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар
ЗТАЖЯ	Зам тээвэр, аялал жуулчлалын яам
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МУЭХ	Монголын урчуудын эвлэлийн хороо
ОУМСХ	Олон улсын монгол судлалын холбоо
МАЭ	Монголын архитекторчдын эвлэл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо болон Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хүсэлт, Үндэсний аудитын газрын 2006 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн дагуу "Их эзэн Чингис хаан хөшөө, Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө" цогцолборыг барьж байгуулахад улсын төсвөөс 2005 онд олгосон хөрөнгийн гүйцэтгэлд аудит хийв.

Энэхүү аудитын зорилт нь "Их эзэн Чингис хаан хөшөө, Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө" цогцолборыг барьж байгуулахад төсвөөс 2005 онд олгосон хөрөнгийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, холбогдох байгууллага, албан тушаалтанд санал, зөвлөмж өгөхөд чиглэгдэв.

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангийн аудитын арга зүйг ашиглалаа. Үүнд:

- Төрийн сангаас захиалагчид олгосон санхүүжилтийн талаар судалгаа, тодруулга авах
- ТЗҮААЭГ-аас НХОГ-т олгосон хөрөнгийн талаар холбогдох байгууллага, санхүүгийн ажилтнуудаас асууж, лавлах
- Гүйцэтгэгч зарим байгууллага, аж ахуйн нэгжийн хийж байгаа ажлын явцыг шалгах
- Ажлын гүйцэтгэлийн баримт материалтай танилцах, шаардлагатай үед холбогдох бусад байгууллагаас тодруулга авах
- Захиалагч, хэрэгжүүлэгчээс гүйцэтгэгчид олгосон санхүүжилтийн талаар судалгаа гаргах

Төрийн хяналт шалтгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Бүлэг 1

Улсын төсвийн санхүүжилтийг хугацаанд нь олгоогүй байна



Танилцуулга

1.1 "Их эзэн Чингис хаан, Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө" цогцолборыг (цаашид "Цогцолбор" гэх) барьж байгуулах талаар шийдвэр гарч, зарим нэг арга хэмжээ авчээ.

1.2 Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар Сүхбаатарын талбай, Д.Сүхбаатар, Х.Чойбалсангийн бунхан, төрийн ордны хойд талын цэцэрлэгийг шинэчлэн засах тухай хэлэлцээд дараахь шийдвэр гаргажээ:

- "Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө", "Монгол төрийн тамга" билэгдлийн хөшөө барих, Д.Сүхбаатарын хөшөөг хүрэл болгох, төрийн ордны гадна засал хийх зэрэг ажлыг зохион байгуулах захиалагчийн үүргийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хариуцуулжээ.
- Дээрх ажлыг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг аль болох улсын төсөвт хүндрэл учруулахгүй шийдвэрлэхийг Санхүү, эдийн засгийн сайд (хуучин нэрээр), Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарт даалгасан байна.
- "Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө", "Монгол төрийн тамга" билэгдлийн хөшөөг байгуулахтай холбогдуулан бунханы болон төрийн ордны арын цэцэрлэгт байрлаж байгаа Д.Сүхбаатар, Х.Чойбалсан. Ж.Самбуу нарын шарилыг шилжүүлэн байршуулах

асуудлыг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзжээ.

- Төрийн ордны барилгыг хүчитгэн бэхжүүлэх, өргөтгөх, засвар, тохижилт хийх асуудлыг судлан боловсруулж, саналаа Засгийн газарт танилцуулахыг Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газар, Нийслэлийн хот байгуулалт, хөрөнгө оруулалтын газрын дарга нарт даалгасан байна.

1.3 Засгийн газрын хуралдааны 2004 оны 8 дугаар сарын 5-ны өдрийн тэмдэглэлд "Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө, цогцолбор" байгуулах ажлыг 2005 онд эхлүүлж шаардагдах зардлыг 2005, 2006 оны төсөвт тусгахаар тогтсон байна.

1.4 "Тулгар төр байгуулагдсаны 800 жилийн их ойг тэмдэглэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2005 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 136 дугаар тогтоолоор Цогцолбор байгуулах болон шарил шилжүүлэн байршуулах ажлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг баталсан.

1.5 "Төрийн ордон, түүний орчныг тохижуулахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2005 оны 49 дүгээр тогтоолоор Төрийн ордон, түүний орчныг шинэчлэн тохижуулах, "Монгол төрийн тамга" билэгдлийн хөшөө байгуулахтай холбогдуулан Ж.Самбуугийн шарилыг төрийн ордны ард байрлах Ардын хувьсгалын талбайгаас Алтан-Өлгийд шилжүүлэн байршуулахаар шийдвэрлэж, Ж.Самбуугийн шарилыг ёслол хүндэтгэлтэйгээр шилжүүлэн, дурсгалын хөшөө босгох ажлыг зохион байгуулахыг Засгийн газарт даалгажээ.

1.6 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай" хуулийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтыг үндэслэн Засгийн газрын 2002 оны 221 дүгээр тогтоолоор Төрийн ордон, Ерөнхийлөгчийн ордон, өргөө, Төрийн харш, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын зориулалтын орон сууц ..., барилга байгууламжийн зураг төсөл, угсралт, засвар үйлчилгээ, тавилга, техник, тоног төхөөрөмж, материал, программ хангамжийг тендерт хамруулахгүй байхаар тогтоожээ.

1.7 Энэ цогцолборыг барьж байгуулах үйл ажиллагаа 3-н үе шаттай хийгдэхээр төлөвлөж төсвөөс 2005 онд 2000,0 сая, 2006 онд 3500,0 сая, 2007 онд 2000,0 сая төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр тооцсон байна.

Улсын төсвийн санхүүжилтийг хугацаанд нь олгоогүй байна


1.8 Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга С.Баярцогт, Сангийн яамны төрийн нарийн бичгийн дарга Ч. Хүрэлбаатар нарын баталсан цогцолборын зураг төсөл, барилга угсралт, уран баримлын ажлын график, санхүүжилтийн хуваарийн дагуу 2005 оны 8 дугаар сард 1142,7 сая, 9 дүгээр сард 265,0 сая, 10

дугаар сард 243,2 сая, 11 дүгээр сард 180,0 сая, 12 дугаар сард 169,1 сая, бүгд 2000,0 сая төгрөгийг санхүүжүүлэхээр шийдвэрлэжээ.

1.9 Гэвч баталсан хуваарийн дагуу санхүүжилт хийгдээгүй байлаа.

Тухайлбал: Улсын төсвөөс 7 дугаар сард 80,8 сая, 8 дугаар сард 348,0 сая, 11 дүгээр сард 45,0 сая, 12 дугаар сард 1526,2 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна.

1.10 Дээрх байдлаас үзэхэд батлагдсан хөрөнгөөс 7, 8 дугаар сард олгосон санхүүжилт 713,9 сая төгрөгөөр дутуу, 9,10 дугаар сард санхүүжилт хийгээгүй, 11 дүгээр сард 135,0 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн бөгөөд 12 дугаар сард үлдэгдэл санхүүжилтийг бүрэн хийсэн байна. Үүнийг диаграммаар харуулбал:



1.11 Дээрх схемээс харахад улсын төсвөөс санхүүжигдсэн хөрөнгийн дийлэнх хувь нь оны эцэст төвлөрчээ.

1.12 Захиалагч ТЗҮААЭГ-аас хэрэгжүүлэгч НХОГ-т зураг төсөл, барилга угсралт, уран баримлын ажлын хөлсөнд зориулж 7 дугаар сард 41,3 сая, 8 дугаар сард 348,0 сая, 12 дугаар сард 660,9 сая, бүгд 1050,1 сая, Дарханы Төмөрлөгийн үйлдвэрт 300,0 сая, Нийслэл Өргөө ХХК-д 187,0 сая, Их Монгол 800 санд 10,0 сая, Чингис хаан мэндэлсний 840 жилийн ой, Монгол Улсын тулгар төр байгуулагдсаны 800 жилийн ойг зохион байгуулах Үндэсний хороонд 168,9 сая, Халиун -Од ХХК-д 27,5 сая, ЗТАЖЯ-нд 6,5 сая, Захиалагчийн товчоонд 28,7 сая төгрөгийг тус тус шилжүүлж, оны эцэст 222,1 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.


1.13 Монгол Улсын тулгар төр байгуулагдсаны 800 жилийн ойг зохион байгуулах Үндэсний хороо нь захиалагч ТЗҮААЭГ-аас санхүүжигдсэн 168,9 сая төгрөгөөс НХОГ-т 120,0 сая, Д.Сүхбаатар, Х.Чойбалсан нарын хөшөөг босгоход зориулж уран барималч Ж.Дүүрэнтөгсөд 19,7 сая, мөн Д.Сүхбаатар, Х.Чойбалсан нарт суврага бүтээхэд 20,0 сая, Төрийн хэлний зөвлөлд 7,2 сая, ОУМСХ-нд 2,5 сая төгрөгийг тус тус шилжүүлжээ.

1.14 НХОГ-т бүгд 1170,0 сая төгрөгийн хөрөнгө төвлөрснөөс "Вертикаль" ХХК-д 316,4 сая, "Ган харш" ХХК-д 212,0 сая, "Нийслэл-Өргөө" ХХК-д 210,0 сая, уран барималч Л.Болдод 203,0 сая, "Цэц манлай", "Арткон", "Гоован", "Өрнөлт проект", "Гидрогео", "Дакон", "Эрчим төсөл" ХХК болон МУЭХ, МАЭ зэрэг байгууллага, аж ахуйн нэгжид 98,6 сая төгрөг шилжүүлж, оны эцэст 130,0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Захиалагч, хэрэгжүүлэгч байгууллагууд гүйцэтгэгчдэд санхүүжилтийг бүрэн олгоогүйгээс хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

1.15 Захиалагч, хэрэгжүүлэгчийн дансанд бүгд 352,1 сая төгрөг зарцуулагдаагүй үлдсэн нь гүйцэтгэгчээс зураг төсөл, уран баримал, барилгын ажлын гүйцэтгэлийг цаг тухайд нь бүрэн гаргаж ирүүлээгүйгээс шалтгаалсан байна.

1.16 Цогцолборыг барьж байгуулахад улсын төсвөөс олгосон хөрөнгийг захиалагч, хэрэгжүүлэгчээс гүйцэтгэгчид санхүүжүүлсэн байдлыг схемээр харуулбал:



Захиалагч гэрээнд тусгагдаагүй байгууллагад хэрэгжүүлэгчээр дамжуулалгүйгээр санхүүжилт олгожээ.

1.17 Захиалагч гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг зөрчиж, түүний дансаар дамжуулалгүй Дарханы төмөрлөгийн үйлдвэр, "Халиун Од" ХХК-д бүгд 327,5 сая төгрөг шилжүүлжээ.

Зураг төсөл, уран баримал, барилга угсралтын ажлын гүйцэтгэлд захиалагчийн зүгээс тавих хяналт хангалтгүй байна.

1.18 Цогцолборын барилга угсралтын ажилд олгогдсон 1647,9 сая төгрөгөөс төвийн хэсгийн газар шорооны ажлын 211,0 сая, бетон суурь, холбогдох бусад ажлын 217,0 сая, хөшөө баримлын ажлын 474,0 сая төгрөгийн гүйцэтгэлд захиалагч хяналт тавьж баталгаажуулсан байна. Энэ нь санхүүжигдсэн хөрөнгийн дөнгөж 54,7 хувь бөгөөд дотоод хяналт хангалтгүй байна.

Зураг төсөл, уран баримал, барилга угсралтын ажлын санхүүжилтээс зориулалт бусаар зарцуулжээ.

1.19 Захиалагч Цогцолборын зураг төсөл, уран баримал, барилга угсралтын ажилд хамаарахгүй зүйлд хөрөнгө зарцуулсан байна. Тухайлбал ЗТАЖЯ-нд 6,5 сая, "Их Монгол 800 сан" -д 10,0 сая төгрөг олгожээ.

1.20 Иймд захиалагчаас ЗТАЖЯ-д шилжүүлсэн 6,5 сая төгрөгийг 2006 оны барилга угсралтын ажлын төсөвт нэмж тооцохыг төрийн санд мэдэгдэж, "Их Монгол 800 сан"-д олгосон 10,0 сая төгрөгийн зээлийг буцаан төлүүлэв.

1.21 Монгол Улсын тулгар төр байгуулагдсаны 800 жилийн ойг зохион байгуулах Үндэсний хороо Цогцолборын барилга угсралтын ажлын санхүүжилтээс Төрийн хэлний зөвлөлд 7,2 сая, ОУМСХ-д 2,5 сая, бүгд 9,7 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан тул холбогдох байгууллагуудаас эргүүлэн авахаар төлбөрийн акт бичлээ.

Зөвлөмж :

Сангийн сайд Н.Баяртсайханд:

- Цогцолборын барилга угсралтын ажлын санхүүжилтийг графикт хугацаанд хийж байх;

ТЗҮААЭГ-ын дарга Ж.Бадраад:

- Цогцолборын хөрөнгийг зориулалтын бус зүйлд зарцуулахгүй байх;
- Зураг төсөл, уран баримал, барилга угсралтын ажлын үе шатанд тавих хяналтыг сайжруулан гүйцэтгэлээр нь санхүүжүүлж ажиллах;

Бүлэг 2

Зураг төсөл эцэслэн гараагүйгээс барилга угсралтын ажил удааширч байна



Танилцуулга

2.1 ЗГХЭГ-ын дарга, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нар 2005 оны 6 дугаар сарын 6-ны өдөр Цогцолборыг барьж байгуулахтай холбогдсон зураг төсөл боловсруулах даалгаврыг баталжээ. Үүнд:

- Хөшөө, баримал, цогцолборын барилгын захиалагчаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газар /ТЗҮААЭГ/, хэрэгжүүлэгчээр НХОГ гэж заасан боловч зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, өдөр тутмын удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах, ажлын гүйцэтгэлийг тооцох зэрэг захиалагчийн гол үүргийг хэрэгжүүлэгчид, харин гүйцэтгэлийн санхүүжилт хийх, газар, техникийн нөхцөлүүдэд зөвшөөрөл гаргуулах зэрэг асуудлыг захиалагчдад хариуцуулсан нь оновчтой бус болжээ.

2.2 НХОГ зураг төсөл боловсруулах 5 байгууллага, барилга угсралтын ажил гүйцэтгэх "Ган харш", "Нийслэл Өргөө", "Вертикаль", "Мандах трейд" ХХК, хөшөө, баримал хийх МУЭХ-ны дарга Л.Болд, тэдгээрийн хоорондын ажлыг уялдуулан зохицуулах инженер нарыг сонгон авч гэрээ байгуулжээ.

2.3 Цогцолборын техникийн зураг төсөл, эскиз-ийг Засгийн газрын хуралдаанаар удаа дараа хэлэлцэж, улмаар уг ажлыг эхлүүлэх, санхүүжилтийг 2005, 2006 оны төсөвт тусган хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн нь хурлын тэмдэглэлд тусгагдсан байна.

Цогцолборын эхний ээлжинд төлөвлөсөн ажил хугацаандаа хийгджээ.

2.4 2005 оны 7 дугаар сарын 14-ний өдрөөс Төрийн ордны өмнө талд барилгын талбайн зохион байгуулалт хийгдэж, Д.Сүхбаатар, Х.Чойбалсан, Ж.Самбуу нарын шарилыг Алтан-Өлгийд шилжүүлэн байршуулахтай холбоотой эхний ажил хийгдсэн байна.

2.5 Энэ ажлын хүрээнд Алтан-Өлгийд шинээр хашаа, бунхан барих, орчныг сэргээн тохижуулах, хотын төвөөс очих замыг хатуу хучилттай болгох зэрэг ажлыг 2005 оны 7 -гоос 11 дүгээр сард гүйцэтгэжээ.

2.6 Сүхбаатар аймгийн төвийн баруун хойд захад Д.Сүхбаатарын дурсгалд зориулсан суврагыг 10,0 сая төгрөгөөр хийж, аймгийн комисст хүлээлгэн өгсөн, Монгол Улсын маршал Х.Чойбалсанд зориулж Дорнод аймагт 19,7 сая төгрөгийн өртөг бүхий хөшөөг бүтээсэн ба харин суврага хийгдээгүй, түүнд шаардагдах 10,0 сая төгрөг аймгийн хөгжлийн сангийн дансанд байна.

Зураг төсөл хугацаандаа хийгдээгүй, гүйцэтгэгч солигдсоноос барилга угсралтын ажил удааширч байна.

2.7 Цогцолборын барилгын хашаа, түр барилгыг барьж, бунханг буулган, барилгын улаан шугам тавьснаар 2005 оны 8 дугаар сарын 26-ны өдрөөс газар шорооны болон барилга барих ажил эхэлсэн байна.

2.8 Гэвч НХОГ анхны гүйцэтгэгч "Ган харш" ХХК-ийг өөрчилснөөс ажлын эрч буурч, дараагийн гүйцэтгэгч "Нийслэл Өргөө" ХХК хашаа, түр барилга, зураг төслийг анхнаас нь дахин хийх болсноос хугацаа алдаж, барилга угсралтын ажил 2 сар орчим түр зогсжээ.

2.9 Уг компани 11 дүгээр сарын эцсээс ажлаа эхэлж цогцолборын төвийн нүүр хэсгийн зүүн талаас гол хүртэл бетон суурь хийж, газраас дээш гарах хэсгийн ажлыг гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлжээ.

2.10 НХОГ-ын сонгосон зураг төслийн "Архитектур" нэгдэлтэй ТЗҮААЭГ гэрээ байгуулж, уг зураг төсөл 2005 оны 8 дугаар сарын 20-нд дуусах байсан боловч объём хэмжээг нэмэх, хасах талаар зарим санал, чиглэл гарч эскиз төлөвлөгөөг баталж зөвшөөрөлцөх гэсээр байгаад хугацаа алдаж 2006 оны 2 дугаар сарын 15-нд дуусгахаар 6 сараар хойшлогджээ.

2.11 Цогцолборыг байгуулахад шаардагдах барилгын материалын захиалга өнөө хүртэл өгөгдөөгүйгээс 2006 оны эхний хагас жилд ашиглалтад өгөх уран баримал, сантехник, барилга угсралтын ажил хугацаандаа хийгдэх боломж муутай байна.

Барилга угсралтын ажилд тавих техникийн хяналтыг онцлон анхаарч бүрэн гүйцэд хийх шаардлагатай байна.

2.12 Зураг төсөл, барилга угсралт, уран баримлын графикт тусгагдсан 14 ажлын 45,3 хувьд захиалагчийн зүгээс гүйцэтгэлийн хяналт тавьж баталгаажуулаагүй байна.

2.13 Цогцолбор анхны хувилбараар 11 хөшөө, барималтай байхаар төлөвлөгдсөн байна.

Зураг 1. Анхны хувилбар:



2.14 Хоёрдахь хувилбараар цогцолборын урд нүүр нь хаадын хөшөө, баримал 11, морьт цэргийн хөшөө 2, шилэн галерейтай байхаар өөрчлөгджээ.

Зураг 2. Хоёрдахь хувилбар:



2.15 Гуравдахь хувилбараар цогцолборын нүүрэн талд Чингис, Өгөдэй, Хубилай хаад, 2 морьт цэргийн хөшөө босгож, тавцанг цагаан гантигаар хийхээр өөрчилсөн байна.

Зураг 3. Гурав дахь хувилбар:



2.16 Одоогийн хувилбарт: Ерөнхийлөгчийн Тамгын газрыг энэ цогцолборт байрлуулах, төрийн ёслолын өргөөг 5 давхар болгох, тавцангийн цагаан гантигийг шар болгох зэрэг өөрчлөлт нэмэгджээ.

Зураг 4. Одоогийн хувилбар:



2.17 Цогцолборын нүүрэн талд 11 хөшөө, баримал байрлуулахаар анхны зураг төсөл гарсныг өөрчилж 3 хаад, 2 морьт цэргийн хөшөө болгосон бөгөөд одоогийн байдлаар хөшөө бүтээх ажлын 80,0 хувь нь хийгдэж хүрлээр цутгах ажил үлдээд байна.

Зураг 5. Хаад болон морьт цэргийн хөшөө



ХУБИЛАЙ ХААН

ЧИНГИС ХААН

ӨГӨДЭЙ ХААН

2.18 Захиалагч, хэрэгжүүлэгчийн ажил давхардсан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа захиалагчийг оролцуулаагүй, захиалагчийн шийдвэргүй гүйцэтгэгчийг сольсон зэргээс барилгын ажил хойшлогджээ.

2.19 Барилгын зураг төслийг олон удаа өөрчилж эцэслэн шийдээгүй, зураг төсөл, барилга угсралтын ажил зэрэг явагдаж байгаагаас барилга угсралтын ажил графикт хугацаандаа хийгдэхгүй, ажлын гүйцэтгэлд тавих хяналт шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна.

ЗӨВЛӨМЖ: 2

Монгол Улсын Засгийн Газарт:

- Хариуцсан ажлаа графикийн дагуу биелүүлэлгүй хугацаа хоцроож, ажил цалгардуулж буй байгууллага, албан тушаалтанд холбогдох арга хэмжээ авах

Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга С.Батболдод:

- Зураг төслийн ажлыг ойрын хугацаанд эцэслэн шийдвэрлэх арга хэмжээ авах;
- Барилга угсралтын ажилд тавих техникийн хяналтыг онцгой анхаарч, бүрэн гүйцэд хийх;
- Барилгын ажлыг оновчтой зохион байгуулан графикийн хоцрогдлыг нөхөх боломжийг эрэлхийлэх;